

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авахаар зохион байгуулсан хэлэлцүүлэг, цахим хуудсуудаар ирүүлсэн саналын товьёг

№	Санал өгсөн иргэний овог, нэр	Ирүүлсэн санал	Тайлбар
Фэйсбүүк цахим хуудсаар ирүүлсэн санал			
1	Zulaa Jantsan	Хөдөө орон нутагт хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд газрыг нь төслийн үр шим ач холбогдлыг үнэлж төсөл сонгон шалгаруулалтаар явуулах заалт маш чухал байна.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийн төсөлд “33.5. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд, эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт, эсхүл улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор олгоно.” гэж, мөн хуулийн төслийн 20.1.8-т “Энэ хуулийн 33.5-д заасан улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн хэмжээнд төсөл шалгаруулах зарчмаар эзэмшүүлэх газрын зориулалтыг тогтоох.” гэж тусгасан тул аймаг, нийслэлийн ИТХ нь мод үржүүлэг байгуулах зориулалтыг төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор баталсан тохиолдолд боломжтой болно.
2		Мөн мод үржүүлгийн газрын үнэлгээ орон нутагт маш өндөр байгааг анхаарч, дуудлага худалдаагаар авахад их өндөр үнэлгээтэй байна	
3		Цашид мод бут тарих, ойжуулах ажлуудыг дэмжих зорилгоор заалт оруулах нь зүйтэй байна.	
4	Flower Flower	Газрын төлөв чанарын хянан баталгаа гэх зүйлийг шаардахгүй болгох нь зөв , хэдэн кадастр хийдэг хүмүүс маш үнэтэй худлаа юм хийдэг тэрийг нь авч хэлэлцсэн ч юм байхгүй , иргэд мөнгө санхүү цаг хугацаагаар хохирдог	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байдаг. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.

5	Davaasuren Ganjuur	Нэр шилжүүлээд авах хооронд хуучин газрыг шинэ гээд өгдөггүйн учир эхлээд гэрчилгээ гаргаж өгчхөөд дараа нь төлөвлөлтөд орсон гээд гэрчилгээ гаргаж өгдөггүйн учир	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем хэрэглээнд нэвтэрсэнтэй холбоотойгоор улсын хэмжээнд өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгогдсон нэгж талбарын хувийн хэргийг нэг бүрчлэн цахимжуулсан. Тэр үед нэгж талбарын хувийн хэрэг, тухайн шатны архиваас эрх олгосон захирамж шийдвэр гаргаагүй тохиолдолд тухайн жилийн төлөвлөгөөнд тусган гэрчилгээжүүлсэн болно.
6	Ц. Оюунгэрэл	Монгол улсын ихэнх иргэн эзэмших газараа авч чадаагүй байна ямар хүмүүс хэдэн га газартай байх юм зарим иргэн 0.7 эзэмших газаргүй байдгийн энэ асуудлыг шийдэх	Газрын тухай хуульд зааснаар нийслэл, сум, дүүрэг жил бүр тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухайн жилдээ олгох газрын хэмжээ, байршил, зориулалтыг баталж олгодог. Мөн түүнчлэн иргэнд ил тод нээлттэй, шударга зарчмыг хангах үүднээс Газрын нэгдмэл сангийн нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж газрыг төлөвлөх, олгох процессыг цахимжуулж ил тод нээлттэй болгосон. Улмаар 2023 онд Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр иргэнд үнэ төлбөргүй олгодог газрыг тодорхой эрэмбийн дагуу олгодог байхаар зохицуулсан. Энэ удаагийн хуульд оруулах гэж буй нэмэлт өөрчлөлтөөр шударга, тэгш зарчмыг хангах үүднээс эрэмбэд хамаарахгүй тохиолдлууд болон иргэн өөрийн харьяалал бүхий аймаг, сумандаа газар авах асуудлыг нарийвчлан тусгаж өгсөн болно.
7	Dorjipalam Shagdar	Гэр бүлийн хэрэгцээний газрын эрхийг шилжүүлэх, хугацаа сунгахад тулгардаг газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа шаардахгүй болгох, шат дамжлагыг арилгах,	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байдаг. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
8		эзэмшиж байгаа газраа өмчилж авах эрхээр хангах	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж буй газрыг өмчлөх асуудал нь хуулийн дагуу иргэн хүсэлтээ гаргасан тохиолдолд шийдвэрлэгдэж байгаа болно.
9	Tserenjav Tsedenbal	@egazar.gov.mn сайтаар захиалга өгөх гэхээр өгсөн. Өөр газар луу шилжүүл гэхээр нь шилжүүлэх гэсээр байтал сайт нь гацаад кадастрын зургийн Pdf файл оруул гэсэн. Оруулж болохгүй байсаар 5 хоногийн хугацаа	Газрын тухай хуульд зааснаар нийслэл, сум, дүүрэг жил бүр тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухайн жилдээ олгох газрын хэмжээ, байршил, зориулалтыг баталж олгодог. Мөн түүнчлэн иргэнд ил тод нээлттэй, шударга зарчмыг хангах үүднээс Газрын нэгдмэл сангийн нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж газрыг төлөвлөх, олгох процессыг цахимжуулж ил тод нээлттэй болгосон. Мөн түүнчлэн 2023 онд Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр Газрын тухай хуульд заасан иргэнд үнэ төлбөргүй олгодог газрыг тодорхой эрэмбийн дагуу олгодог байхаар зохицуулагдсан. Энэ удаагийн хуульд оруулах гэж

		дууссан. Ингэж газар олгомооргүй байна. Зураг яаж хавсаргах талаар тайлбар бичээч. Ард түмнээ хуурсан ажил хийх юм.	буй нэмэлт өөрчлөлтөөр шударга, тэгш зарчмыг хангах үүднээс эрэмбэд хамаарахгүй тохиолдлуудыг нарийвчлан тусгаж өгсөн. Цахим системийг иргэд, олон нийтэд ил тод, хүртээмжтэй, энгийн хялбар болгохоор хөгжүүлэлтийн ажлыг шат дараатай хийж байна.
10	Ц. Оюунгэрэл	эзэмших газраа өмчлөх болгох хэзээнээс эхэлж бичиг баримтаа авах вэ?	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж буй газрыг өмчлөх асуудал нь хуулийн дагуу иргэн хүсэлтээ гаргасан тохиолдолд шийдвэрлэгдэж байгаа болно.
11		удаан явлаа ш дээ хянан баталгаа хийлгэж очингуут авахгүй ямар учиртай юм бэ?	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байдаг. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
12	Баясгалан Баясаа	2015 онд цахимаар газар олгосон Багануур дүүргийн нутаг Тариан булаг хэмээх газрыг одоо болтол ямар ч суурьших боломжгүй 1 айл ч хашаа хатгаагүй хэдэн хаймар дугуй булсан нөхцөл байдалтай байсаар байна энэ хугацаанд ард иргэд бид маш их хохиролтой байна.үүнд ямар нэгэн шийдэл гарц гаргалаа хийнэ үү.	Газрын тухай хуулийн 40.1.6-д “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй” бол газар эзэмших эрхийн гэрчилгээг аймаг, сум, нийслэлийн Засаг дарга хүчингүй болгох хуулийн заалттай. Мөн түүнчлэн газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих нь аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах нь Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх юм. Харин Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасныг зөрчсөн тохиолдолд шүүхийн журмаар хурааж авах хуулийн зохицуулалттай.
13	Onjoo Ouyntsetseg	Зуслангийн газраа өмчлөх эрхтэй, үгүйг яаж мэдэх вэ	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газартай холбоотой төрийн үйлчилгээг www.egazar.gov.mn хаягаар болон харьяалах газрын алба, газрын даамалд хандан авах боломжтой.

14	Jambaa Oyun	Хянан баталгааны дүгнэлтийг авахыг болих хэрэгтэй	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байдаг. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
15	Нямхуяг Мандахгэрэл	Амьдралд шууд хэрэгжих хууль баталмаар байна. 0.7 га газрыг суманд гэж бүтэн 2 жил болж байна. Мөн хүн амьдрахгүй бол газар өгдгийг болих.	Хуулийн төслийн 29.13-т “Тухайн аймаг, сумын засаг захиргааны нэгжид харьяалалтай, өмнө нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэ төлбөргүй газар эзэмшиж, өмчилж байгаагүй иргэний хүсэлтийг энэ хуулийн 29.8.1-д заасан эрэмбийн эхэнд бүртгэнэ.”, 29.14-т “нийслэлээс хөдөө орон нутагт шилжин ирсэн, гамшиг ослын улмаас орон гэргүй болсон, эсхүл нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар эзэмших хүсэлтийг эрэмбэ, дараалал харгалзахгүй шийдвэрлэнэ.” гэж тус тус тусгасан.
16		Ойрхон төвийн газруудаа хамаатнууддаа өгч, бусдад өгөхөө болохоор уулын мухарт өгдгийг болих, эзэмшихээр хашаа барьчихаад хүн амьдраагүй 10 жил болсон маш олон газар байна үүнийг цэгцлэх	Газрын тухай хуульд зааснаар нийслэл, сум, дүүрэг жил бүр тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухайн жилдээ олгох газрын хэмжээ, байршил, зориулалтыг баталж олгодог. Мөн түүнчлэн иргэнд ил тод нээлттэй, шударга зарчмыг хангах үүднээс Газрын нэгдмэл сангийн нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж газрыг төлөвлөх, олгох процессыг цахимжуулж ил тод нээлттэй болгосон. Улмаар 2023 онд Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр иргэнд үнэ төлбөргүй олгодог газрыг тодорхой эрэмбийн дагуу олгодог байхаар зохицуулсан. Энэ удаагийн хуульд оруулах гэж буй нэмэлт өөрчлөлтөөр шударга, тэгш зарчмыг хангах үүднээс эрэмбэд хамаарахгүй тохиолдлууд болон иргэн өөрийн харьяалал бүхий аймаг, сумандаа газар авах асуудлыг нарийвчлан тусгаж өгсөн болно. Мөн Газрын тухай хуулийн 40.1.6-д “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй” бол газар эзэмших эрхийн гэрчилгээг аймаг, сум, нийслэлийн Засаг дарга хүчингүй болгох хуулийн заалттай. Мөн түүнчлэн газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих нь аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах нь Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх юм. Харин Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 28

			дугаар зүйлд заасныг зөрчсөн тохиолдолд шүүхийн журмаар хурааж авах хуулийн зохицуулалттай.
17	Nyamka Nymka	Хянан батлах гэж сүлжээ болцон мөнгө угаах арга болимоор юм	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
18	Tsetsgee Dorjgotov	Газрыг нөхөн сэргээх сайжруулах. мод үржүүлэх. тэжээлийн ургамал тариалах талбайг газрын төлбөрөөс чөлөөлөх заалт оруулах.	Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Саналыг тус хуулийн төсөлд харгалзана.
19	Tseveen Badam	1. Газрын төлөвлөгөөт ХБ ажлыг газрын тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд хийж, Газрын мониторингийг үндэсний сүлжээг шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйгээр хийх.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
20		Өөрсдийн хөрөнгөөр газрын нөхөн сэргээлт хийсэн, хөрсний үржил шимийг сайжруулж эвдрэлээс хамгаалах арга хэмжээ авсан иргэн ААНд газрыг давуу эрхээр эзэмшүүлэх, өмчлүүлэх.	Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 “Хүний үйл ажиллагааны улмаас элэгдэл, эвдрэлд орж, ашиглалтгүй орхигдсон газрыг өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн газрыг аймаг, нийслэлийн байгаль орчны газрын дүгнэлтийг үндэслэн эзэмшүүлж болно.” гэж заасан байдаг.
21		ГНС ангиллын шилжилт хөдөлгөөнийг тухай бүр хийхдээ ГТБЧХБ хийдэг болгох	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
22		Газрын суурь судалгаа, зураглалын ажлын стандартуудыг сайжруулан батлах, хувийн ААН-н хийсэн ажилд техникийн хяналт	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.

		тавих, хийгдсэн ажлын үр дүнг улсын хэмжээнд нэгтгэн бодлого боловсруулагчдыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах институцийг бий болгох	
23		Хөрсний лабораторитой болж хувийн лабораторийн ажилд магадлал хийдэг болох	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
24	Оюнаа Оюнаа	0.7 аваагүй хүмүүс яаралтай олгох	Монгол Улсын иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмших хүсэлтээ цахим системээр дамжуулан гаргах бөгөөд цахим систем нь ирсэн хүсэлтийг эрэмбэлэн эхэнд эрэмбэлэгдсэн иргэнд газрын эрх олгох зарчмаар зохицуулж байна. Харин тус хуулийн төслийн 6/29 дүгээр зүйлийн 29.12 дахь хэсэг: 29.13-т “аймаг, суманд тухайн засаг захиргааны нэгжийн харьяалал бүхий өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд үнэгүй газар авч байгаагүй иргэний хүсэлтийг энэ хуулийн 29.8.1-т заасан эрэмбийн эхэнд бүртгэнэ.” гэж тусгасан.
25	Цэнджав Дашдулам	Газрын хянан баталгаа нэхдэггүй болмоор байна. Хувь компаниуд маш өндөр үнэ нэхэж байна.	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байдаг. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
26	Л. Баярпүрэв	Хянан баталгаа гэж шал худалдаа зүйлээ болих хэрэгтэй. Нэг бол үнэ тарифыг нь буулгах тал дээр анхаарахгүй бол дурын үнээ хэлэх юм. 180к, 200к 250к гэх мэтээр	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байдаг. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.

www.gazar.gov.mn цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн санал			
1	12/7/2025 19:51	33.5 нэмэлтээр хүний үйл ажиллагааны улмаас элэгдэл эвдрэлд орсон газрыг өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн бол гэж нэмэх	Тус хуулийн төслийн 1/20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт:-д “20.1.8.Энэ хуулийн 33.5-д заасан улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын зориулалтыг тогтоох.” гэж тусгасан. Ингэснээр тухайн төслийн зориулалтыг орон нутаг өөрийн эрх хэмжээний хүрээнд тогтоох боломжтой болох юм. Энэхүү хуулийн төсөлд тусгагдаагүй асуудлыг Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
2	12/8/2025 12:55	Гэвч тусгай зөвшөөрлөөрөө юу, хэсэгчилж үү гэдэг нь тодорхойгүй байгаад асуудал байна	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
3	12/8/2025 21:35	Шалгуурт нийцсэн иргэнд газар олголтын хугацааг багасгах.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд иргэний өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааг нарийвчлан тусгасан байдаг. Мөн Газрын тухай хуульд 2023 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх хүсэлтийг шийдвэрлэх хугацааг тус тус заасан байдаг.
4		Хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай, онцгой нөхцөл үүссэн иргэнд газар олголтыг 72 цагийн дотор шийдвэрлэх түргэвчилсэн горим нэвтрүүлэх.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд иргэний өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааг нарийвчлан тусгасан байдаг. Мөн Газрын тухай хуульд 2023 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх хүсэлтийг шийдвэрлэх хугацааг тус тус заасан байдаг.
5		Гомдол шийдвэрлэх хугацааг хуульд зааж өгөх Газартай холбоотой гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэх зохицуулалт	Тус хуулийн төслийн 33.9-т “Энэ хуулийн 37.2, 38.4-т заасан хүсэлтийг шийдвэрлэхдээ энэ хуульд зааснаас бусад нөхцөл, шаардлага тавихыг хориглох бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй бол тухайн шатны Засаг дарга шалтгаан, үндэслэлийг хүсэлт гаргагчид мэдэгдэх үүрэгтэй.”, 33.10-т “Хүсэлтийг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл энэ хуулийн 33.9-д заасныг зөрчсөн тухай гомдлыг нийслэл, дүүрэгт Нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлд, аймаг, суманд дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд тус тус гаргана.” гэж тусгасан

			бөгөөд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд иргэний өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааг нарийвчлан тусгасан байдаг.
6	12/8/2025 22:52	Газрынхаа хэвлийд байгаа нөөцийн хэмжээг давтамжтай судалгаа явуулах хамгийн том жишээ Эрдэнэт үйлдвэр Эрдэнэт хот нэг хүнд ноогдох газар нутгийн хэмжээгээрээ газар доорхи баялаг хот хоёрын зөрчил уурхайн хотын төлөвлөлт тэсэлгээ судалгаа экологийн даац хөгжлийн бодлого зэргээ харгалзан үзэж хуулиа баталмаар юм. Эртний олдворын судалгааг хийхгүй дээр хэдэн боловсролгүй даамлууд хэдэн халтар төгрөгөөр бүгдийг нь зараад дуусчихсан	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.Тус хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.8-т “Хууль, тогтоомжийн дагуу тогтоосон газар ашиглалтын дэглэм, горим бүхий хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын бүс, зурвас газрын болон зам, шугам сүлжээ, ойн сан, усны сан бүхий газар, хот байгуулалт, тусгай хамгаалалттай газар, газрын тос болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий газрын орон зайн мэдээллийг бүрдүүлэх асуудлыг хариуцсан байгууллага нь Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгүүлэх үүрэг хүлээнэ.” гэж тусгасан.
7	2025-12-09 01:59:10	40.1.8 Газрын тухай хуулийн 29.3 дахь заалтын дагуу үр тариа,төмс хүнсний ногооны чиглэлээр газар эзэмших эрхийн дагуу эзэмшсэн газрынхаа тодорхой хэсгийг 2 жил дараалан бүрэн гүйцэт ашиглаагүй тохиолдолд ашиглаагүй хэсгийг хураан авч дахин хуваарилах зарчмыг баримтална. Орон нутагт том талбай хашчихаад багахан хэмжээнд газар тариалангийн үйл ажиллагаа эрхлээд байдаг иргэд их байна.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.

8	12/9/2025 11:38	<p>Газрын ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй аймаг сумдын газрын албанд хариуцлагыг маш чанга тооцдог болох талаар буюу заавал биелэгдэх шинжтэй зүйл байхад биелүүлээгүй. Жишээ нь: Увс аймгийн газрын алба газрын ерөнхий төлөвлөгөөгөө гаргаж өгөөгүйгээс болоод 2025 онд огт газар өгөөгүй гэсэн мэдээлэл өгч байсан одоо 2025 онд газар авахаар хүсэлт өгсөн иргэдийн газрыг 2026,2027 онд өгөх талаар ярьж байна. Ажлаа хангалттай хийгээгүйн улмаас иргэд цаг хугацаагаараа хохирсоор байна.</p>	<p>Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д аймаг, нийслэлийн газрын албаны эрх хэмжээг заасан байдаг. Тус хуулийн төсөлд тусгагдаагүй зохицуулалтыг Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах явцад харгалзана.</p>
9	12/9/2025 13:28	<p>Ерөнхий төлөвлөгөө нэрээр намаг дотор хурдны зам барих төсөл хийж тэндээ удаан амьдарсан хүнд өмчлөх эрх өгөхгүй хүнд суртал гаргах нь хэрээс хэтэрлээ.</p>	<p>Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.3-т "хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" гэж хот, тосгоны хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн хот байгуулалтын үндсэн баримт бичгийг гэж туссан байдаг. Энэхүү баримт бичгийг боловсруулахдаа байр зүйн зураглал, инженер-геологийн дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, нийгэм, эдийн засгийн үнэлгээ, газар ашиглалтын судалгаа болон бусад холбогдох суурь судалгааг хийж хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцооны үндсэн элемент болох дэд бүтцийн хөгжил болон ирээдүйд хэлбэршин тогтох олон нийт, нийгэм ахуйн үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай барилга байгууламж, архитектур, орон зайн хөгжлийн чиг хандлага, байгалийн эрдэс түүхий эд, байгаль экологийн тэнцвэрт байдал, хүрээлэн буй орчныг ашиглах, хамгаалах арга замыг урьдчилан тодорхойлдог. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь байгаль орчин, нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, архитектур орон зайн төлөвлөлтийг техникийн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулдаг урт хугацааны орон зайн төлөвлөлтийн баримт бичиг бөгөөд газрыг төлөвлөх, олгох үйл ажиллагааг тус төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн зохион байгуулдаг.</p>

10	12/9/2025 13:30	Улаанбаатар хот Зайсангийн ам, ХУД 22-р хороонд 1957 оноос одоог хүртэл амьдарч байгаа иргэд А гэрчилгээгээр 2015 оноос гэрчилгээжүүлж байгаа. А гэрчилгээтэй хүмүүст тохиолддог нийтлэг зүйл нь:гэрчилгээний хугацаа богино.татвар хэт өндөр,хашааны газраа бусдад шилжүүлж болдоггүй, эдгээр саналыг оруулахыг хүсэж байна.	Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах асуудал нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулдаг болно. Мөн Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн яам Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж байгаа тул тус хуулийн хэлэлцүүлгийн явцад нь санал өгөх боломжтой. Цаашид судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
11	12/9/2025 14:15	Газрын ямар нэг зориулалтаар авчаад буцаагаад зардаг явдлыг зогсоож хуульдаа өөрчлөлт оруулах	Өнөөгийн хуулийн зохицуулалтаар газрыг өмчлөх, эзэмших, ашиглах гэсэн эрхийн 3 төрөлтэй байхаар зохицуулсан байдаг. Газар ашиглах эрх нь захиран зарцуулах эрхгүй, харин газар өмчлөх, эзэмших эрх нь хууль, тогтоомжид нийцүүлэн захиран зарцуулах эрхтэй тул иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь хуулийн хүрээнд өмчилж, эзэмшиж буй газраа эрх бүхий этгээдийн шийдвэрээр бусдад шилжүүлэх боломжтой байдаг.
12	12/9/2025 18:55	15.1.Усны сан бүхий газарт нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газар хамаарна. Үүнийг усны сан бүхий газар гэж усны тухай хуульд томьёолсон газар нутгийг хэлнэ гэж оруулах.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
13	12/9/2025 19:34	Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар орон нутагт ажиллаж байгаа анхан шатны Газрын даамлын ажлын ачаалал улам их болно ядаж хуулийн өөрчлөлтөөр цалинг яриач	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.

		сумандаа хамгийн их ачаалалтай ажилладаг албан хаагч шүү авч байгаа цалин бусад албан хаагчаас доор шүү эхлээд албан хаагчаа бодох хэрэгтэй	
14	12/9/2025 20:05	Эзэмшил болон өмчлөлийн газрын хэмжээг 200м2 дотор аймаг сумын засаг дарга газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулахгүй өөрчилдөг байх.	Газрын тухай хуулиар газар эзэмших, ашиглах эрхийн харилцааг, өмчлөх харилцааг Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар зохицуулдаг. Энэхүү боловсруулсан хуулийн төсөл нь орон нутагт нэн тэргүүнд тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд боловсруулагдсан бөгөөд зөвхөн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар үзэл баримтлалын төсөл батлагдаад байна. Мөн Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Эзэмшил газрын хэмжээ, байршлыг дараах тохиолдолд өөрчилж болно:”, 29.11-т “Энэ хуулийн 29.10-т заасан шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” гэж тус тус заасан байдаг.
15	12/9/2025 22:31	Хуулийн өөрчлөлтийн 58.7-д хувийн гэр орон сууц хашаа барих зориулалтаар эзэмшүүлж гэсний ард ашиглуулж гэж, 3.3.4.6-д малчид гэдгийн ард иргэнд гэж оруулах.мөн гэрчилгээний хугацаа богино 15 жилээр гэж,хашааны газраа бусдад шилжүүлж болдоггүйг болдог болгох.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
16	12/9/2025 22:37	Орон нутгийн иргэдэд газар олголтыг давуу эрхээр өгөх буруу байна. Хэн дуртай нь хаана хамаагүй газар олгож малын бэлчээргүй болгож хашаалж байна. Иргэдэд адил тэнцүү олгох зүйтэй. Мөн 1 иргэнд дээд талдаа 5 га газраас хэтрэхгүй олгох нь зүйтэй.	Хуулийн төсөлд тусгагдсан тэжэээлийн ургамал тариалах зориулалтаар 5 га хүртэлх газрыг олгох асуудал хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хасагдсан.

17	12/9/2025 23:33	Газрын байршил зориулалт өөрчлөх орон нутагт бас байх нь зөв	Дэмжсэн санал байна.
18	12/10/2025 1:57	Газар анх эзэмшүүлсэн мөн дээрээ амьдарч үйл ажиллагаа явуулдаг бол хамгаалалтын бүсийг харгалзахгүй эрх шилжүүлэх, хугацаа сунгах мөн газрын дуудлага худалдааны үнийг 2010 оноос хойш тооцож авах дуудлага худалдааны бүсчлэлийг дахин тогтоох шаардлагатай тул санал оруулж өгнө үү.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
19	12/10/2025 11:00	Нэг хүнд олон газар өгч газрын наймаа хийлгэхгүй байх. Газрын албыг хүнд сурталгүй байлгах. Газрын сонголтыг гаргаж өгөх	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
20	12/8/2025 12:54	“33.9.Энэ хуулийн 33.5-д заасан улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын зориулалтыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтооно. ГЭСЭНД аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 5 ЖИЛД НЭГ УДАА Ч ЮМ УУ ЖИЛДЭЭ НЭГ УДАА Ч ЮМ УУ ЯМАР НЭГЭН ХУГАЦАА ЗААЖ ӨГӨХГҮЙ БОЛ ТУХАЙ БҮР НЬ	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.

		ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АСУУДАЛ ГАРАХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.	
21	12/10/2025 21:11	23.2.4 дэх заалтыг хүчингүй болгох санал оруулах. Аймаг, нийслэлийн ИТХ эрх хэмжээнд байгаа асуудлаар давхардуулан ЗГ шийдвэр гаргах шаардлагагүй.	Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4-т “улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;” гэж заасан байдаг бөгөөд хуулийн төсөлд тус заалтыг “улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын шилжилт хөдөлгөөний жилийн төлөвлөгөөг боловсруулж Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих” гэж өөрчлөн тусгасан.
22		29.10.9 дэх заалтыг дахин судлах. Онцгой байдлын газар ийм дүгнэлт гаргаж болох эсэх.	Саналыг хүлээн авч хуулийн төслөөс хассан.
23		29.12 дахь заалтыг дахин судалж найруулах, ахмад настан, нийслэлээс хөдөө орон нутагт шилжсэн иргэн гэх мэт хэт өргөн хүрээг хамарсан байгааг анхааран үзэх. Нийтэд нь зүйл, заалтын найруулгыг сайжруулах	Саналыг хүлээн авч судлан хуулийн төслийн 29.14-т “Нийслэлээс хөдөө орон нутагт шилжин ирсэн, гамшиг ослын улмаас орон гэргүй болсон, эсхүл нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар эзэмших хүсэлтийг эрэмбэ, дараалал харгалзахгүй шийдвэрлэнэ.” гэж найруулсан.
24	12/10/2025 21:44	Газар олголтыг тухайн дүүрэгт нь шууд шийдвэрлэдэг баймаар байна нийслэл рүү шийдвэрлэхээр ачааллаа дийлэхгүй маш удах юм мөд шийдвэрлэж өгөхгүй байна.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.

25	12/10/2025 23:40	Хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоож далан дагуух айлуудад газрыг олгох. Даланг шинэчлэх. Улаанбаатар хот доторх голуудыг шулуун чигт урсацыг нэг чигт болгож голдирлыг өөрчлөх тэгвэл далангийн эвдрэл багасаж иргэдийн аюулгүй байдал хангагдана	Усны сан бүхий газрын асуудлыг Усны тухай хуулиар зохицуулдаг болно. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах явцад харгалзана.
26	12/11/2025 7:31	Тиймээ санал нийлж байна.	Дэмжсэн санал
27	12/12/2025 8:04	Орон сууц, барилгын доод газрыг бүх өмчлөгч нарт өмчилж буй талбайн хэмжээгээр бага ч хамаагүй хувааж өмчлүүлж гэрчилгээ олгох, нэг этгээд газар дээрээ байшин барьчихаад дараа нь гэрчилгээгээ барьцаалж зээл авч байна. Тэгээд бусдад алдвал тэр байрныхан хөөгдөнө ш дээ	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах явцад харгалзана.
28	12/17/2025 10:11	Дэмжиж байна	Дэмжсэн санал
29	12/17/2025 10:24	Дэмжиж байна	Дэмжсэн санал
30	12/17/2025 10:27	Эзэмшил газрын хэмжээг нэмэгдүүлэх, өөрчлөхийг аймаг сумын Засаг дарга бие даан шийдвэрлэдэг байх.	Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Эзэмшил газрын хэмжээ, байршлыг дараах тохиолдолд өөрчилж болно.” гэж талбайн хэмжээ, байршлыг өөрчлөх тохиолдлуудыг зааж, тус шийдвэрийг 29.11-т “Энэ хуулийн 29.10-т заасан шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” гэж тус тус заасан байдаг.
31	12/17/2025 11:28	Эзэмшил газрын хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтэй байна.	Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Эзэмшил газрын хэмжээ, байршлыг дараах тохиолдолд өөрчилж болно.” гэж талбайн хэмжээ, байршлыг өөрчлөх тохиолдлуудыг зааж, тус шийдвэрийг 29.11-т “Энэ хуулийн 29.10-т заасан шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн

			ерөнхий төлөвлөгөө болон эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” гэж тус тус заасан байдаг.
32	12/17/2025 15:10	Газар сунгах асуудлыг оруулах	Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Эзэмшил газрын хэмжээ, байршлыг дараах тохиолдолд өөрчилж болно:” гэж талбайн хэмжээ, байршлыг өөрчлөх тохиолдлуудыг зааж, тус шийдвэрийг 29.11-т “Энэ хуулийн 29.10-т заасан шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” гэж тус тус заасан байдаг.
33	12/17/2025 18:55	1 21 дүгээр зүйлийн 21.3.3 дахь заалт дээр ХЭЛБЭР ӨӨРЧЛӨХ гэж нэмж оруулах саналтай байна	Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Эзэмшил газрын хэмжээ, байршлыг дараах тохиолдолд өөрчилж болно:” гэж талбайн хэмжээ, байршлыг өөрчлөх тохиолдлуудыг зааж, тус шийдвэрийг 29.11-т “Энэ хуулийн 29.10-т заасан шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” гэж тус тус заасан байдаг.
34	12/17/2025 19:02	1 21 дүгээр зүйлийн 21.3.3 дахь заалт дээр хэлбэр өөрчлөх гэж оруулахаар санал өгч дэмжиж байна	Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Эзэмшил газрын хэмжээ, байршлыг дараах тохиолдолд өөрчилж болно:” гэж талбайн хэмжээ, байршлыг өөрчлөх тохиолдлуудыг зааж, тус шийдвэрийг 29.11-т “Энэ хуулийн 29.10-т заасан шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” гэж тус тус заасан байдаг.
35	12/17/2025 22:46	21 дүгээр зүйлийн 21.3.3 дээр хэлбэр өөрчлөх	Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Эзэмшил газрын хэмжээ, байршлыг дараах тохиолдолд өөрчилж болно:” гэж талбайн хэмжээ, байршлыг өөрчлөх тохиолдлуудыг зааж, тус шийдвэрийг 29.11-т “Энэ хуулийн 29.10-т заасан шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” гэж тус тус заасан байдаг.
36	12/18/2025 0:31	Газрын хэмжээ нэмэгдүүлэхийг тухайн аймаг нийслэлийн засаг дарга шийдвэрлэдэг байх	Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Эзэмшил газрын хэмжээ, байршлыг дараах тохиолдолд өөрчилж болно:” гэж талбайн хэмжээ, байршлыг өөрчлөх тохиолдлуудыг зааж, тус шийдвэрийг 29.11-т “Энэ хуулийн 29.10-т заасан шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” гэж тус тус заасан байдаг.
37	12/18/2025 11:47	хуулийг дэмжиж байна	Дэмжсэн санал

38	12/23/2025 9:31	Засгийн газраараа орохгүйгээр шууд сумын ИТХурлаараа шийдээд явах нь зүйтэй.	Санал хуулийн төсөлд тусгагдсан.
39	12/23/2025 17:34	Газрын зориулалт өөрчлөх асуудлыг ерөнхий төлөвлөгөөтэй уялдаж байгаа тохиолдолд орон нутагт аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлэхгүйгээр зориулалт өөрчилдөг байх гэж нэмэлтээр оруулах.	Хуулийн төсөлд 29.11-т “Энэ хуулийн 29.10-т заасан болон эзэмшил газрын зориулалт өөрчлөх шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, эдэлбэр газрын бүсчлэл, газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” гэж тусгасан.
40	1/3/2026 21:21	Амьдрах орчинтой болох	Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд хамаарахгүй санал байна.
41	1/7/2026 1:09	2025.11.13-нд хүсэлт өгсөн боловч одоо болтол хариу өгөөгүй байна	Газрын тухай хуульд заасны дагуу тухайн жилд батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газрыг олгох асуудал тухайн шатны Засаг даргад байдаг.
42	1/9/2026 14:15	Газрын хүсэлтээ аваач ээ	Газрын тухай хуульд заасны дагуу батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газрыг олгох асуудал тухайн шатны Засаг даргад байдаг. www.egazar.gov.mn цахим хуудсаар газрын хүсэлтийг авч байна.
43	1/11/2026 12:57	Ажилгүй 3 хүүхэдтэй нуруу хугаралттай иргэн би өөрийн өмчилсөн газаргүй тул хурдан өөрийн гэсэн газартай болмоор бна	Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд хамаарахгүй санал байна. Газрын тухай хуульд заасны дагуу батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газрыг олгох асуудал тухайн шатны Засаг даргад байдаг.
44	1/26/2026 10:07	Өөрийн хөрөнгөөр ногоон байгууламж (мод тарих) бий болгож тухайн сум орон нутагтаа хүлээлгэж өгөх хүсэлтэй иргэн, аж ахуй нэгжийн газар олголтыг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох боломжийг бүрдүүлсэн хуулийн заалт оруулж өгвөл зүгээр байна.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
Албан бичгээр иргэдээс ирүүлсэн			

1	1. Иргэн Ш. Уламсайхан болон нэр бүхий 115 иргэдийн санал	Гэр бүлийн хэрэгцээний газрын эрхийн шилжүүлэх, хугацааг сунгахад тулгардаг газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт шаардахгүй болгох шат дамжлагыг арилгах нь гэдэгт санал нэг байна.	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байдаг. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
2		Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах 58.7-д оруулсан хувийн гэр орон сууц хашаа байшин барих зориулалтаар эзэмшүүлэх гэсэн заалтад мөн ашиглуулах гэж оруулж мөн хуулийн 3.3.4.6-д малчид гэж заасанд иргэд гэж давхар оруулбал иргэд өргөн хүрээтэй хамрагдах боломж бүрдэнэ	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
3		Эзэмшүүлэх эрхийн гэрчилгээтэй иргэдийг газар дээрээ 2 жил үйл ажиллагаа явуулаагүй, ашиглаагүй гэдэг шалтгаанаар гэрчилгээг цуцалдаг байдлыг гэр ахуйн хэрэгцээнд авсан газарт хамааралгүй болгох	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
4		Тусгай хамгаалалттай газар нутагт ашиглах эрхийн гэрчилгээтэй газар зөрчилгүй тохиолдолд эзэмшигчийн нэр шилжүүлж болох талаар заалт оруулах	Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах асуудал нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулдаг болно. Мөн Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн яам Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж байгаа тул тус хуулийн хэлэлцүүлгийн явцад нь санал өгөх боломжтой. Цаашид судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй
5		Газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг 5	Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.

		<p>жилээр олгодог байдлыг 10-15 жилийн хугацаагаар олгодог болгох, гэрчилгээний хугацаа дууссанаас хойш сарын дотор гэрчилгээг сунгуулах материалыг хүлээн авдаг болгох заалтыг хуульд оруулах. Учир нь одоогоор газар ашиглах гэрчилгээ дээр Байгаль орчны сайдын тушаал гарсан огноо мөн гэрчилгээ бичсэн огноо гээд 2 он сар өдөр байдаг ба иргэд гэрчилгээ авсан өдрөөр тооцож материалаа өгөхөд сайдын тушаалын хугацаа өнгөрсөн гээд яльгүй шалтгаанаар 3 сая төгрөгөөр торгож иргэдийг дарамталж хохироож байна. Өмнө нь торгууль 500.000 төгрөг байсныг нийслэлийн прокурор Наранхүү гэж хүн тогтоол гаргаж нэмсэн иргэдийг амьдралд улам дарамт болсон. Иймд цаашид газрын тухай хуульд газар ашиглах эрхийн хугацааг сайдын тушаал гарсан өдрөөс биш газар ашиглах гэрээ байгуулсан өдрөөс хойш тооцож байхаар тусгах мөн иргэдэд эхлээд гэрээгээ дүгнүүлэх мэдэгдлийг хүргүүлсэн байх заалт оруулах нь чухал байна.</p>	
--	--	--	--

6		<p>Иргэдийг 3 сая төгрөгөөр торгодог, газраа ашиглаагүй гээд гэрчилгээг цуцалдаг явдал нь жирийн иргэдэд хүндээр тусч мөн том ялгаварлан гадуурхалт болж байна. Учир нь тусгай хамгаалалттай газар нутаг гээд газрын төлбөр өндөр тэгээд Тусгай хамгаалалттай газар ашиглах гэрчилгээ олгохдоо Аялагч, зөвшөөрөл бүхий иргэд отоглох буудаллах гэсэн зориулалтаар олгодог гэтэл баячууд яг ийм зориулалтаар жирийн иргэдтэй адил газар аваад орон сууц барьж өндөр үнээр худалддаг, өндөр өндөр стандарт бус төмөр хашаа барьж уулнаас бууж ирдэг зэрлэг амьтдад эрсдэл учруулдаг, газрын төлбөр татвар төлдөггүй зэргээр хууль зөрчиж байхад ямар ч хуулийн хариуцлага тооцож чаддаггүй хэрнээ жирийн иргэд авсан газраа хууль бусаар ашиглаж байгаль орчинд хохирол учруулаагүй, газар дээрээ барилга орон сууц барьж худалдаж хууль зөрчөөгүй газраа онгон унаган төрхөөр нь хадгалж, татвар мөнгө төлсөн байхад газрын гэрчилгээг цуцалдаг явдлыг болиулах</p>	
---	--	--	--

		<p>үүнийг ялгаж салгаж шийдвэрлэдэг болох заалт хуульд оруулах.</p>	
7		<p>Одоогийн хуулийн заалтаар Газар ашиглах зориулалтаа өөрчлөн Орон сууцны хороолол, хашаа барьсан, зарсан худалдсан, байгаль орчин сүйтгэж хууль зөрчсөн нь зөвдөж, газраа унаган төрхөөр нь хадгалсан хамгаалсан иргэд нь буруудаж торгууль шийтгэл хүлээдэг хуулийн заалтыг хянан үзэх, зөв заалт оруулах</p>	
8		<p>Ер нь тусгай хамгаалалттай газар нутагт нэгэнт иргэдийн суурьшлын бүс бий болсон тохиолдолд / тухайлбал Дархан цаазат Богдхан уулын Зайсангийн ам болон бусад ам/ тухайн хэсгийг тусгай хамгаалалтаас гаргаж, орон нутагт шилжүүлж, иргэдэд олгосон ашиглах эрх бүхий газрыг эзэмшүүлэх болгож байх хуулийн заалт оруулах нь чухал байна.</p>	

9		Газрын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтүүд нь аль болох иргэдэд ээлтэй амьдралд нь эдийн засаг санхүүгийн дарамтгүй, олон шат дамжлагагүй иргэд газрын гэрчилгээг сунгуулахдаа цахимаар хүсэлтээ гаргавал авлига хээл хахуульд өртөхгүй байна.	
---	--	--	--

Нээлттэй нийгэм форум сан НҮТББ-тай хамтран 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан хэлэлцүүлэг

1	Завхан Баянтэс даамал	Хилийн тухай хуулийн 26.3.1 д Хилийн зурвас газар газар эзэмшүүлэх өмчлүүлэхийг хориглосон нь Хилийн зурваст малчид амьдрах эрхгүй болж байна. Өвөлжөөний газраа эзэмшиж чадахгүй мөн тариалан эрхлэх боломжгүй гэх мэт олон асуудлууд тулгарч байна. Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн үндсэн эрх зөрчигдөж байна. Уг хилийн тухай хуулийн заалтыг хүчингүй болгож өгнө үү.	Хилийн тухай хуулийн 26.2.2-т “Улсын хилийн зурваст хил хамгаалалтын зориулалттайгаас бусад барилга байгууламж барих, үйл ажиллагаа явуулах, газар ашиглах асуудлыг Засгийн газар шийдвэрлэх” гэж заасан байдаг бөгөөд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул саналыг судлан үзэж Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах явцад харгалзана.
2	Хэнтий Хэрлэн сум	Өвөлжөө хаваржааны газрын олгохдоо 1 иргэнд олгох тоог зааж өгмөөр байна. Мөн өвөлжөө хаваржааны газрын эрх шилжүүлэхийг хоригломоор байна.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул судлан үзэж Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж буй Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналыг харгалзана.
3	Архангай Өндөр-Улаан Засаг дарга	Өвөлжөө хаваржааны газрыг нэг малчинд өвөлжөө болон хаваржааны нэг нэг газар эзэмшүүлмээр байна.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудал тул саналыг судлан үзэж Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах явцад харгалзана.

4		Өвөлжөө хаваржааны газрын эрх шилжүүлэхийг хоригломоор байна.	
5	Өвөрхангай Есөнзүйл Эрдэнэчимэг	Сайн байна уу? Өвөрхангай аймаг Есөнзүйл сум манай сум нь эргэлтийн 2880 га газартай 2015-2016 онд 2400 га газрыг 2 аж ахуй нэгж авсан байдаг. Одоогоор 2 жил өнжөөд 50 га газар тарьчихаад алга болчихдог. Үүн дээр арга зүйн зөвлөгөө өгөөч	Хуулийн төсөлд хамаарахгүй.
6	Иргэн	Маш томоор бэлчээр хашаалаад байгаа асуудлыг шийдмээр байна.	Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.11-т “Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг хашихыг хориглоно.” гэж заасан байдаг тул тухайн нэгж талбарыг ямар зориулалтаар олгогдосон талаарх мэдээллийг www.egaza.gov.mn цахим хаягаас харах боломжтой. Мөн тухайн асуудлаар харьяа Газрын албанд хандаж тодруулах боломжтой.
7	Архангай Өндөр-Улаан Засаг дарга	Атар газрыг хагалах эрх олгох гэж байгаа энэ ажил хэр удаан үргэлжлэх вэ	Тариалангийн тухай хуульд зааснаар тариалангийн ангилалд шилжүүлээгүй атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглосон байдаг.
8	BAYARAA SWB MONGOLIA	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Үзэл баримтлал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дах заалт дагуу Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн тайлангаа танайх сайт дээрээ нээлттэй болгох хэрэгтэй байна Энэ хэлэлцүүлэгт орж байгаа хүмүүст бүгдэд и-мэйлээр илгээх шаардлагатай	Хуулийн төслийн батлагдсан үзэл баримтлал болон холбогдох судалгаа тайланг эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем legalinfo.mn сайтад байршуулсан тул https://legalinfo.mn/mn/discussiondetail/17435554149562?type=LIS_LAW&page=1 -холбоосоор нэвтрэн танилцах боломжтой.
9	"Ховдын Толь сонин" НҮТББ-Г.Төрмөнх	Үзэл баримтлал боловсруулахдаа оролцоог хангах тухай ойлголт огт алга шиг ээ! Үзэл баримтлал боловсруулах нь хэдэн эрх мэдэлтэй нөхөд, ганц нэг	Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тус хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалгааг хийсэн бөгөөд тус хуулийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоож танилцуулсан болно.

		байгууллагын дурын хэрэг гээд нут итгэчихсэн л яваад шиг	
